

"МОНРЕ ДААТГАЛ" ХХК

1. Гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгуулагчийн зөвшөөрөлгүй этгээд автотээврийн хэрэгслийг жолоодож яваад осол гаргасан;
2. Даатгуулагч болон түүний зөвшөөрөлтэй этгээд осол болох үед
 - 2.1.1 согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн байсан;
 - 2.1.2 жолоодох эрхгүй эсвэл жолоодох эрхийн үнэмлэхгүйгээр тээврийн хэрэгслийг жолоодсон;
3. Нөхөн төлбөр шийдвэрлэгдээгүй байхад даатгагчтай зөвшилцөлгүйгээр автотээврийн хэрэгслийг устгасан, зарсан;
4. Даатгалтай автотээврийн хэрэгслийг уралдаан тэмцээнд ашигласан, даац хэтрүүлсэн, техникийн хүчин чадлын хувьд зорчих боломжгүй газраар жолоодсон, гарам болон зам гаргаагүй хэсгээр гол гарсан, мөсөн дээгүүр явсан;
5. Даатгуулагчийн хууль бус үйлдлийн улмаас учирсан хохирол;
6. Буруутай этгээдээр учирсан хохирлоо төлүүлсэн болон учирсан хохирлын үр дагавраас үүсэх аливаа хохирол;
7. Нотлогдох боломжгүй болсон хохирол;
8. Гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол улсын нутаг дэвсгэрийн гадна учирсан хохирол;
9. Мэргэжлийн байгууллагад аваар осол, хохирлын талаар газар дээр нь мэдэгдэж үзлэг шалгалт хийлгэн акт дүгнэлт гаргуулаагүй, гэрээнд заасан хугацаанд даатгагчид мэдэгдэж, хохиролтой холбоотой материалыг даатгалын тохиолдол болсон өдрөөс хойш ажлын 132 хоногийн дотор даатгагчид бүрэн ирүүлээгүй;
10. Автотээврийн хэрэгслийг хууль тогтоомжийн дагуу хураасан, устгасан, дайчилгаанаас үүдэлтэй хохирол;
11. Цацраг идэвхит бодис, цөмийн зэвсэг, цөмийн түлш, тэсрэх бөмбөг бусад тэсрэх бодис, байлдааны зэвсгийн үйлчилгээнээс үүдэлтэй шууд болон шууд бус үр дагавараас шалтгаалсан хохирол;
12. Дайн байлдаан, улс төрийн болон террорист үйл ажиллагаа, ажил хаялт, төрийн эргэлт, бослого, үймээн самууны үр дагавар;
13. Хуучрах, зэврэх, ердийн элэгдэл болон үйлдвэрийн гологдол /дефект/, автотээврийн хэрэгслийн хүчдэл дамжуулж буй бүхий холболтууд буюу цахилгааны утасны гэмтэл түүний үр дагавар;
14. Зүсэгдсэн, урагдсан, замын иртэй зүйлсээс эсвэл тормозлосноос шалтгаалж хагарч буудсан дугуйнд учирсан хохирол;
15. Зам тээврийн ослоос бусад шалтгаанаар автотээврийн хэрэгслийн ашиглалтаас үүдэлтэй явах хэсгүүдийн эд ангид учирсан хохирол, түүний үр дагавар;
16. Гэрээнд өөрөөр заагаагүй бол үйлдвэрийн бус нэмэлт тоног төхөөрөмж, нэмэлт хэрэгслүүдэд учирсан хохирол;
17. Даатгуулагч автотээврийн хэрэгслийг зайлшгүй зогсолтоос бусад шалтгаанаар замын зорчих хэсэгт зогсоосон үед учирсан хохирол;
18. Автотээврийн хэрэгслийн эзэмшигч өөрчлөгдсөн талаар даатгагчид мэдэгдэж гэрээнд заасан хугацаанд даатгалын гэрээ болон баталгааг шинэчлээгүй;
19. Замын хөдөлгөөнд оролцохдоо тээврийн хэрэгслийн хурд хэтрүүлсэн.